



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/136/СТА-ТШЗ

Баянхонг ор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг: tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт               |
| АОУС     | Аудитын олон улсын стандарт                                 |

## Агуулга

|       |  |    |
|-------|--|----|
| 1     | Аудитын гэрчилгээ.....   | 3  |
| 2     | Аудитын тайлан .....   | 5  |
| 2.1   | Оршил.....   | 5  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 5  |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                       | 6  |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....  | 6  |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 7  |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....   | 8  |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....  | 9  |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....   | 9  |
| 2.8.1 | Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал.....  | 9  |
| 2.8.2 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....                                   | 10 |
| 2.9   | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.....                          | 10 |
| 2.10  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....  | 10 |
| 2.11  | Шилэн дансны мэдээлэл .....  | 10 |
| 2.12  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....  | 11 |
| 2.13  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....  | 11 |
| 3     | Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....   | 12 |
| 3.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....  | 12 |
| 3.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....   | 13 |
| 3.3   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....  | 14 |
| 3.4   | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....   | 15 |
| 3.5   | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....  | 16 |

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ШАРГАЛЖУУТ ТОСГОНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРАГЧ Ц.НАСАНБАЯР ТАНАА Г

2019.02.25 № 2/66

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох

2019 on gerchilgee\_Shargaljuut tosgonii Zahiragchiin alba.docx

2519113

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 Оршил**

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Ц.Насанбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөгөөг тухай бүр нь өгсөн болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.0.20-ноос 2019.02.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр 2019.01.08-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба нь Захирагчийн алба нь нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт, шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны “Төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэж иргэн бүр үр бүтээлтэй хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.” зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүнийг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ” хангамж ашигладаг байна.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 49899,5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 978.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

### **2.8.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал**

Тус байгууллага өөрийн эзэмшилд 2018 онд шилжиж ирсэн цэцэрлэгийн барилгын газрыг Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтаар оруулаагүй үнэлгээг тайланд тусгасан байна.

Аудитын явцад тус байгууллага Энх нахиа ХХК-ний Хөндлөнгийн хараат бус мэргэшсэн үнэлгээчин Л.Наранцэцэгээр 2019.02.27-ны өдөр газрын дахин үнэлгээнд Үнэлгээний нягтлан шалгалт хийлгэхэд газрын үнэлгээг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 4-р хавсралтад заасан үнэлгээгээр үнэлснийг залруулж дээрх тогтоолын 6 дугаар хавсралтад заасан бусад сумын төвийн тосгоны 1 га газрын суурь үнэ 2000 төгрөгөөр үнэлснээс санхүүгийн тайланд 6.0 сая төгрөгийг илүү тусгасныг санхүүгийн тайланд залруулав.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### **2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудал байхгүй.

### **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

байхгүй

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд орон нутгийн төсвөөс 36493,9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж бүрэн авч, 168,2 мянган төгрөгийн орлогыг буцаан төвлөрүүлсэн байна.

Өөрийн байрны түрээсийн орлогоор 8616,4 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрснийг зарцуулаагүй буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 оны 11 дүгээр сарын 20-д хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-

аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 23 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож бусад мэдээллийг хугацаанд нь мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

#### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/ төгрөг/

| Дансны код  | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл              | Эцсийн үлдэгдэл              |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b><u>1,423,600.00</u></b>  | <b><u>4,554,166.65</u></b>   |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | 00.00                       | 71,666.65                    |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 00.00                       | 1,666.65                     |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>   | 00.00                       | 70,000.00                    |
| 3351        | Байгууллагаас авах авлага   | 00.00                       | 70,000.00                    |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 1,423,600.00                | 4,482,500.00                 |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | 1,423,600.00                | 4,482,500.00                 |
| 35410       | Бичиг хэргийн материал  | 215,100.00                  | 213,500.00                   |
| 35420       | Аж ахуйн материал   | 183,500.00                  | 183,500.00                   |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл   | 1,025,000.00                | 2,333,000.00                 |
| 35440       | Түлш, шатах тослох материал   | 00.00                       | 1,752,500.00                 |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>60,972,501.63</u></b> | <b><u>146,133,836.49</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 60,972,501.63               | 146,133,836.49               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | 60,972,501.63               | 143,733,836.49               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц  | 62,129,338.00               | 248,146,257.00               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл   | -9,705,412.22               | -106,832,471.84              |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл  | 28,280,392.00               | 28,280,392.00                |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл   | -25,321,242.00              | -26,943,790.72               |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 4,930,503.00                | 4,930,503.00                 |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | -3,514,577.15               | -4,152,552.95                |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 2,130,115.00                | 2,130,115.00                 |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | -1,754,115.00               | -1,824,615.00                |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө  | 7,350,000.00                | 00.00                        |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл   | -3,552,500.00               | 00.00                        |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | 00.00                       | 2,400,000.00                 |
| 39301       | Програм хангамж   | 200,000.00                  | 200,000.00                   |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | -200,000.00                 | -200,000.00                  |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 00.00                       | 2,400,000.00                 |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>62,396,101.63</u></b> | <b><u>150,688,003.14</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b><u>00.00</u></b>         | <b><u>47,834.65</u></b>      |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 00.00                       | 47,834.65                    |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | 00.00                       | 47,834.65                    |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг   | 00.00                       | 1,666.65                     |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>  | 00.00                       | 46,168.00                    |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг  | 00.00                       | 46,168.00                    |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>62,396,101.63</u></b> | <b><u>150,640,168.49</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 62,396,101.63               | 150,640,168.49               |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 55,799,679.53               | 58,199,679.53                |

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|            |  |                      |                       |
|------------|--|----------------------|-----------------------|
| 51101      | Өмч: - төрийн                                      | 55,799,679.53        | 58,199,679.53         |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | <b>6,468,884.10</b>  | <b>92,312,950.96</b>  |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                 | 6,468,884.10         | 6,468,884.10          |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                               | 00.00                | 85,844,066.86         |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   | 127,538.00           | 127,538.00            |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>62,396,101.63</b> | <b>150,688,003.14</b> |

**3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**  
СТ-2А

төгрөг

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл  | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                       | <b>31,628,803.00</b> | <b>135,743,571.76</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>00.00</b>         | <b>89,678,271.76</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | <b>00.00</b>         | <b>89,678,271.76</b>  |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 00.00                | 89,678,271.76         |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 00.00                | 89,678,271.76         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>31,628,803.00</b> | <b>46,065,300.00</b>  |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>00.00</b>         | <b>9,571,400.00</b>   |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00                | 9,571,400.00          |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>26,481,900.00</b> | <b>36,493,900.00</b>  |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/          | 26,481,900.00        | 36,493,900.00         |
| <b>1330</b> | <b>Төсвийн захирагчдаас</b>  | <b>5,146,903.00</b>  | <b>00.00</b>          |
| 133003      | Хөрөнгийн  | 5,146,903.00         | 00.00                 |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>32,117,159.69</b> | <b>49,899,504.90</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>32,117,159.69</b> | <b>49,899,504.90</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | <b>31,139,503.72</b> | <b>41,114,911.18</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                     | <b>19,101,561.99</b> | <b>23,001,274.33</b>  |
| 210101      | Үндсэн цалин   | 19,101,561.99        | 23,001,274.33         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                        | <b>2,062,342.04</b>  | <b>2,742,192.95</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 1,312,399.48         | 1,840,101.84          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 156,642.27           | 230,012.73            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 180,831.88           | 166,050.39            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 37,497.13            | 46,002.53             |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 374,971.28           | 460,025.46            |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                             | <b>1,840,000.00</b>  | <b>4,915,557.00</b>   |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 280,000.00           | 830,557.00            |
| 210302      | Түлш, халаалт  | 1,560,000.00         | 4,085,000.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                      | <b>1,775,000.00</b>  | <b>1,226,600.00</b>   |
| 210401      | Бичиг хэрэг  | 95,000.00            | 241,600.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 1,560,000.00         | 880,000.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 120,000.00           | 105,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                     | <b>00.00</b>         | <b>1,055,650.00</b>   |
| 210604      | Урсгал засвар  | 00.00                | 1,055,650.00          |

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|        |   |                    |                      |
|--------|---|--------------------|----------------------|
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | 145,340.00         | 1,256,700.00         |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж        | 145,340.00         | 1,256,700.00         |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | 6,215,259.69       | 6,916,936.90         |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал   | 200,000.00         | 00.00                |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол  | 6,015,259.69       | 6,916,936.90         |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | 977,655.97         | 8,784,593.72         |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | 900,000.00         | 00.00                |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                     | 900,000.00         | 00.00                |
| 2134   | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | 77,655.97          | 168,193.72           |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 77,655.97          | 168,193.72           |
| 2135   | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | 00.00              | 8,616,400.00         |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 00.00              | 8,616,400.00         |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                                   | <b>-488,356.69</b> | <b>85,844,066.86</b> |
| 5      | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>  | <b>-488,356.69</b> | <b>85,844,066.86</b> |

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан  
СТ-3А

төгрөг

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл  | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|----------------------|-----------------------|
|            | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>  |                      |                       |
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                                | <b>26,481,900.00</b> | <b>46,065,300.00</b>  |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>26,481,900.00</b> | <b>46,065,300.00</b>  |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 00.00                | 9,571,400.00          |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00                | 9,571,400.00          |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | 26,481,900.00        | 36,493,900.00         |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/          | 26,481,900.00        | 36,493,900.00         |
| 2          | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                                 | <b>26,481,900.00</b> | <b>46,065,300.00</b>  |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>26,481,900.00</b> | <b>46,065,300.00</b>  |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | <b>25,504,244.03</b> | <b>37,280,706.28</b>  |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                     | 19,125,004.03        | 22,584,699.28         |
| 210101     | Үндсэн цалин   | 19,125,004.03        | 22,584,699.28         |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                        | 2,038,900.00         | 3,112,600.00          |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 2,038,900.00         | 2,347,200.00          |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 00.00                | 191,300.00            |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал  | 00.00                | 153,100.00            |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал   | 00.00                | 38,300.00             |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 00.00                | 382,700.00            |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                             | 1,840,000.00         | 6,588,057.00          |
| 210301     | Гэрэл, цахилгаан   | 280,000.00           | 830,557.00            |

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |   |                     |                     |
|-------------|---|---------------------|---------------------|
| 210302      | Түлш, халаалт   | 1,560,000.00        | 5,757,500.00        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                     | <b>1,175,000.00</b> | <b>1,305,000.00</b> |
| 210401      | Бичиг хэрэг   | 95,000.00           | 225,000.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 960,000.00          | 960,000.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 120,000.00          | 120,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | <b>980,000.00</b>   | <b>2,363,650.00</b> |
| 210604      | Урсгал засвар   | 980,000.00          | 2,363,650.00        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | <b>145,340.00</b>   | <b>1,326,700.00</b> |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж        | 145,340.00          | 1,326,700.00        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | <b>200,000.00</b>   | <b>00.00</b>        |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 200,000.00          | 00.00               |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>977,655.97</b>   | <b>8,784,593.72</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>900,000.00</b>   | <b>00.00</b>        |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                     | 900,000.00          | 00.00               |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | <b>77,655.97</b>    | <b>168,193.72</b>   |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 77,655.97           | 168,193.72          |
| <b>2135</b> | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | <b>00.00</b>        | <b>8,616,400.00</b> |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 00.00               | 8,616,400.00        |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                     | <b>00.00</b>        | <b>00.00</b>        |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                    | <b>00.00</b>        | <b>00.00</b>        |

3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
СТ-4А

төгрөг

| Код | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн    | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|----------------------|--|
| D01 | <b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>55,799,679.53</b>            | <b>127,538.00</b>     | <b>6,468,884.10</b>  | 62,396,101.63                          |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 00.00                           | 00.00                 | 00.00                | 00.00                                  |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>55,799,679.53</b>            | <b>127,538.00</b>     | <b>6,468,884.10</b>  | 62,396,101.63                          |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00                           | 00.00                 | 00.00                | 00.00                                  |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 00.00                           | 00.00                 | 00.00                | 00.00                                  |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                 | 00.00                | 00.00                                  |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 00.00                           | 00.00                 | 00.00                | 00.00                                  |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | 2,400,000.00                    | 00.00                 | 85,844,066.86        | 88,244,066.86                          |
| D09 | <b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>58,199,679.53</b>            | <b>127,538.00</b>     | <b>92,312,950.96</b> | 150,640,168.49                         |

### 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

төгрөг

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Өмнөх оны             |               | Тайлант оны           |               |
|-----------------------|--|-----------------------|---------------|-----------------------|---------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл     | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл     |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 28,850,300.00         | 25,435,846.93 | 36,493,900.00         | 36,325,706.28 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 28,850,300.00         | 25,435,846.93 | 36,493,900.00         | 36,325,706.28 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 28,850,300.00         | 25,435,846.93 | 36,493,900.00         | 36,325,706.28 |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 23,647,200.00         | 21,249,582.00 | 22,584,700.00         | 22,584,699.28 |
| 210101                | Үндсэн цалин   | 23,647,200.00         | 21,249,582.00 | 22,584,700.00         | 22,584,699.28 |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 2,601,100.00          | 2,296,464.93  | 3,112,600.00          | 3,112,600.00  |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 2,601,100.00          | 2,296,464.93  | 2,347,200.00          | 2,347,200.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 00.00                 | 00.00         | 191,300.00            | 191,300.00    |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 00.00                 | 00.00         | 153,100.00            | 153,100.00    |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 00.00                 | 00.00         | 38,300.00             | 38,300.00     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 00.00                 | 00.00         | 382,700.00            | 382,700.00    |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 460,000.00            | 460,000.00    | 6,668,000.00          | 6,588,057.00  |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 160,000.00            | 160,000.00    | 1,180,000.00          | 830,557.00    |
| 210302                | Түлш, халаалт  | 300,000.00            | 300,000.00    | 5,488,000.00          | 5,757,500.00  |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 1,517,000.00          | 1,204,800.00  | 1,365,000.00          | 1,305,000.00  |
| 210401                | Бичиг хэрэг  | 97,000.00             | 36,000.00     | 225,000.00            | 225,000.00    |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 1,320,000.00          | 1,068,800.00  | 960,000.00            | 960,000.00    |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 100,000.00            | 100,000.00    | 180,000.00            | 120,000.00    |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 00.00                 | 00.00         | 2,365,200.00          | 2,363,650.00  |
| 210604                | Урсгал засвар  | 00.00                 | 00.00         | 2,365,200.00          | 2,363,650.00  |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 225,000.00            | 225,000.00    | 398,400.00            | 371,700.00    |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 225,000.00            | 225,000.00    | 398,400.00            | 371,700.00    |
| 2109                  | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 400,000.00            | 0.00          | 0.00                  | 0.00          |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 400,000.00            | 00.00         | 00.00                 | 00.00         |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 28,850,300.00         | 25,435,846.94 | 36,493,900.00         | 36,325,706.28 |
| 1320                  | <b>ОРОН НУТГИЙН</b>  | 28,850,300.00         | 25,435,846.94 | 36,493,900.00         | 36,325,706.28 |

Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|           | <b>ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                   |               |               |               |               |
|-----------|--|---------------|---------------|---------------|---------------|
| 132001    | Орон нутгийн төсвөөс                       | 28,850,300.00 | 25,435,846.94 | 36,493,900.00 | 36,325,706.28 |
| <b>62</b> | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                    | 4             | 4             | 5             | 5             |
| 620001    | Удирдах ажилтан                            | 1             | 1             | 1             | 1             |
| 620002    | Гүйцэтгэх ажилтан                          | 1             | 1             | 1             | 1             |
| 620003    | Үйлчлэх ажилтан                            | 2             | 2             | 3             | 3             |
| <b>65</b> | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                 | <b>4</b>      | <b>4</b>      | <b>5</b>      | <b>5</b>      |
| 650001    | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)         | 1             | 1             | 1             | 1             |
| 650009    | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1             | 1             | 1             | 1             |
| 650010    | Гэрээт ажилтан                             | 1             | 1             | 2             | 2             |
| 650011    | Улс төрийн албан хаагч (УТ)                | 1             | 1             | 1             | 1             |